

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА Д. МӨРӨН

ШШГЕГ -ЫН ХАРЬЯА БАРИВЧЛАХ
ТӨВИЙН ДЭРГЭДЭХ, ГАДААДЫН
ИРГЭНИЙГ СААТУУЛАХ БАЙРНЫ
ДАРГА, ХУРАНДАА Д. АЛИМАА

БАЙГАЛИЙН ГАМШИГ ГЭНЭТИЙН АЮУЛ БҮХИЙ ОНЦГОЙ НӨХЦӨЛ
ҮҮССЭН ТОХИОЛДОЛД АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

2017 оны 11 сарын 28 өдөр

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү төлөвлөгөөний зорилго нь Шүүхийн шийдвэр шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн дэргэдэх Гадаадын иргэнийг саатуулах байранд байгалийн гамшиг, гэнэтийн аюул бүхий онцгой нөхцөл байдал үүссэн үед саатуулагдаж буй этгээд, объектыг зохих хяналтад авч, учирч болох хор уршиг, эрсдэлийг багасгах, таслан зогсоход чиглэсэн үйл ажиллагааг хамтран зохион байгуулахад оршино.

1.2. Байгалийн гамшиг гэнэтийн аюул бүхий онцгой нөхцөл байдал гэдэгт үер усны аюул, хүчтэй шуурга, гал түймрийн аюул, газар хөдлөлт, хүн малын гоц халдварт өвчин болон саатуулах байранд гэмт хэргийн шинжтэй шалтгаан нөхцөл үүссэн тохиолдол болон улс орны хэмжээнд онц байдал зарласан, нүүлгэн шилжүүлэг хийгдэх, цахилгаан, дулааны хангамжгүй болсон тохиолдол бүрийг ойлгох бөгөөд онцгой нөхцөл үүссэн үед энэ төлөвлөгөөний дагуу ажиллана.

1.3. Үүссэн онцгой нөхцөл байдлыг Шүүхийн шийдвэр шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн дэргэдэх Гадаадын иргэнийг саатуулах байрны /цаашид "Саатуулах байр" гэх/ хүч хэрэгслээр таслан зогсоох боломжгүй тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, харьяа дүүргийн цагдаагийн байгууллага, онцгой байдлын алба, эмнэлгийн болон бусад төрөл мэргэжлийн байгууллагад шуурхай мэдэгдэн дэмжлэг авна.

Хоёр. Байгалийн гамшиг гэнэтийн аюул бүхий онцгой нөхцөл байдал үүссэн талаар зарлан мэдээлэх

2.1. Байгалийн гамшиг, гэнэтийн аюул бүхий онцгой нөхцөл байдал үүссэн талаар мэдээлэл хүлээн авсан, илрүүлсэн, нөхцөл байдал үүсэж болзошгүй тохиолдолд Саатуулах байрны жижүүр нэн даруй Саатуулах байрны дарга, Гадаадын иргэн, харьяатын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шуурхай удирдлагын төвийн жижүүр, цагдаа, онцгой байдал, эмнэлгийн байгууллагад мэдэгдэж хойшлуулшгүй үйл ажиллагааг шуурхай авна.

2.2. Саатуулах байрны даргаас үүрэг авсан жижүүр энэхүү бэлэн байдлын төлөвлөгөөг задлан алба хаагчдад байгалийн гамшиг гэнэтийн аюул бүхий онцгой нөхцөл байдал үүссэн, үүсэж болзошгүй талаар болон дадлага сургалт явуулах зорилгоор доорх таних нэрээр зарлан мэдээлнэ. Үүнд:

- **Сонор**-Албаны сургалт дадлага, бэлэн байдлыг хангуулах, шалгахад;

- **Шуурга 1**-Саатуулагдаж буй этгээдүүдийн зүгээс гэмт хэрэг, үймээний шинжтэй нөхцөл байдал үүссэн, халдлага үйлдэгдсэн, нүүлгэн шилжүүлэг хийгдэх болсон тохиолдолд;
- **Шуурга 2**-Улс орны хэмжээнд онц байдал зарласан, байгалийн гамшиг гэнэтийн аюул, гал түймрийн аюул, хүн малын гоц халдварт өвчингарсан, цахилгаан, дулааны хангамжгүй болсон тохиолдолд.

Гурав. Байгалийн гамшиг гэнэтийн аюул бүхий онцгой нөхцөл байдал үүссэн объектод алба хаагчдыг дуудан ирүүлэх үйл ажиллагаа

3.1. Онцгой нөхцөл байдал үүссэн үед саатуулах байрны дарга алба хаагчдыг бэлэн байдалд дуудах талаар жижүүрт үүрэг өгч удирдах байгууллагад хэрхэн ямар арга хэмжээ авч ажиллаж байгаа, нөхцөл байдлын талаар шуурхай танилцуулан, мэдээлэл авсан алба хаагчдад нэмэлт үүрэг даалгавар өгч үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

3.2. Мэдээ, мэдээлэл хүлээн авсан албан хаагч бүр таних нэрийн нөхцөл байдалд тохируулан хувийн бэлтгэлийг хангаж түргэн цугларч, саатуулах байрны даргад мэдээ мэдээлэл хүлээн авсан болон ирсэн цаг минутыг илтгэн, нэмэлт үүрэг даалгавар авч ажиллана.

3.3. Онцгой нөхцөл байдал үүссэн үед алба хаагчдын ирэх маршрут, объектод ирэх цаг хугацаа, гэрийн хаяг, шаардлагатай үед холбогдох утасны жагсаалт зэргийг энэхүү төлөвлөгөөний хавсралтад тусгасан байна.

Дөрөв. Байгалийн гамшиг гэнэтийн аюул бүхий онцгой нөхцөл байдал үүссэн үед авах хойшлуулшгүй үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт

4.1. Саатуулах байранд байгалийн гамшиг гэнэтийн аюул бүхий онцгой нөхцөл байдал үүссэн үед нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, үйл ажиллагааг шуурхай удирдлага, зохион байгуулалтаар хангах "Шуурхай штаб"-ыг байгуулж болно.

4.2. Шуурхай штабын дарга нь Саатуулах байрны дарга байх бөгөөд бүрэлдэхүүн нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын газар, холбогдох эмнэлгийн байгууллага, төрөл мэргэжлийн байгууллагын удирдах, гүйцэтгэх алба хаагчдаас бүрдэнэ.

4.3. Шуурхай штабаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, байгалийн гамшиг гэнэтийн аюул бүхий онцгой нөхцөл байдал үүссэн объектод ажиллах бүрэлдэхүүнд дэмжлэг үзүүлэх зорилгоор холбоочин, хэлмэрч /орчуулагч/, цахилгаанчин, сан техникч, жолооч, харуул хамгаалалтын нэмэлт хүч, зураг, дүрс баримт бүрдүүлэх ажилтан болон бусад төрөл мэргэжлийн байгууллагын албан тушаалтныг татан оролцуулна.

4.4. Байгалийн гамшиг гэнэтийн аюул бүхий онцгой нөхцөл байдал үүссэн үед алба хаагчид, саатуулагдаж байгаа этгээдүүд, саатуулах байрны эд аж ахуйг түр байрлуулах, нүүлгэн шилжүүлэх газар, байр сууц, хүнс, хувцас хангалтыг хэрхэн хангах талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газартай хамтран шийдвэрлэнэ.

Тав.Төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих

5.1. Байгалийн гамшиг гэнэтийн аюул бүхий онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах бэлэн байдлын төлөвлөгөөний биелэлт, нууцлалд саатуулах байрны дарга биечлэн хяналт тавьж, албан хаагчдын хөдөлгөөн хийгдэх бүр төлөвлөгөөний хавсралтад баяжилт хийж байхыг холбогдох албан тушаалтан бүр үүрэг өгч, хяналт тавьж ажиллана.

5.2.Гадаадын иргэн, харьяатын газар, Саатуулах байр хамтран байгалийн гамшиг гэнэтийн аюул бүхий онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах үйл ажиллагааг хэвшүүлэх сургалт дадлагыгхагас жилд нэг удаа зохион байгуулж албан хаагчдыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана.

Зургаа.Байгалийн гамшиг гэнэтийн аюул бүхий онцгой нөхцөл байдал үүссэн үед албан хаагчдын мэдвэл зохих зүйл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

6.1.Саатуулах байр нь Байгалийн гамшиг гэнэтийн аюул бүхий онцгой нөхцөл байдал үүссэн үед болон нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.1.1.Саатуулах байрны алба хаагч бүр бэлэн байдлын төлөвлөгөөтэй танилцаж гарын үсэг зурж баталгаажуулантус, тусын үүргийг мэдсэн байна;

6.1.2.эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх эм, тариа, боох материалын нөөц бүрдүүлэх;

6.1.3. болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор харуул хамгаалалтын тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал найдвартай ажиллагааг хангуулахын тулд тогтмол шалгаж зөрчлийг тухай бүр нь арилгах арга хэмжээг авах талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Баривчлах төв болон Гадаадын иргэн, харьяатын газарт хандаж шийдвэрлүүлнэ;

6.1.4. этгээдүүдийн зүгээс гарч болзошгүй гэмт хэргийн шинжтэй үйлдэлд хариу арга хэмжээг шуурхай авах, мэдээллийг шуурхай дамжуулах, тэмдэглэл хөтлөх, телекамер, дүрс, дуу бичих төхөөрөмж ашиглах, санал хүсэлтийг бичгээр авах, үйл хөдлөл, яриа өгүүлэл, сэтгэл санааны байдалд нь дүгнэлт хийх, хариуцсан хяналтын улсын байцаагчаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар шаардлагатай мэдээлэл авах;

6.1.5.этгээд олноор ирсэн тохиолдолд алба хаагчдыг хүч нэмэгдүүлэх зорилгоор дуудан ирүүлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт нэмэлт хүч татан авах, санал хүргүүлэх ажлыг зохион байгуулах;

6.1.6. этгээдүүд хоол, цай идэж уухгүйбайх /өлсгөлөн зарлах/, эмнэлгийн тусламж авахаас татгалзах /эм уухгүй байх/ тохиолдолд авах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, этгээдийн зүгээс ямар шаардлага тавьж байгааг урьдчилсан байдлаар тогтоож, уг этгээдийг тусгаарлан, Гадаадын иргэн харьяатын газарт мэдэгдэн, шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд саатуулах байрны жижүүр, эмч, сувилагч, тоо бүртгэлийн ажилтан үйл ажиллагааны тэмдэглэл хөтлөн шаардлагатай бол зураг, дүрс, дуу бичлэгийн төхөөрөмж ашиглан баримтжуулж болно;

6.1.7. Гадаадын иргэнийг саатуулах байрны дотоод журмын 10.1, 10.3, 10.4-д заасны дагуу онцгой нөхцөл байдалд ашиглагдах тусгай хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангаж ажиллана;

6.1.8. бэлэн байдлын төлөвлөгөөнд 20,000 төгрөг /хорин мянга/, 2500 хүртэл төгрөгийн /хоёр мянга таван зуун/ Gmobilyтасны нэгжийг картаар дугтуйд хийн нууцалсан байна.

Долоо. Хүлээлгэх хариуцлага

7.1. Албан хаагч бүр энэхүү төлөвлөгөөг үүссэн нөхцөл байдалтай уялдуулан мөрдөн ажиллах ба зөрчвөл хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.